28

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 02 сарын 05 өдөр Дугаар 8/08 Номгон

Баяр наадам зохион байгуулах аймгийн
хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит YIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Тулгар төрийн 2231, Их Монгол Улс байгуулагдсаны 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 111, Ардын хувьсгалын 101 жил, Баянхонгор аймгийн Богд сумын уугуул Монгол Улсын Арслан Пагамын Аюушийн мэндэлсний 100 жилийн ой, Хэл шинжлэлийн ухааны доктор, профессор Сономын Лувсанвандангийн мэндэлсний 90 жилийн ой, Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ой, Баянхонгор аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах аймгийн хороог дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Хорооны дарга: Б.Батсуурь
(Аймгийн Засаг даргын орлогч)

Бүтээн байгуулалт хариуцсан хороо Ж.Мөнхсоёл
(Аймгийн Засаг даргын орлогч)

Ёслол хүндэтгэл хариуцсан хороо: Д.Энхжаргал
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх хороо: С.Байгалмаа
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Бөхийн барилдаан хариуцсан хороо: Т.Хишигбаатар
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Хурдан морины уралдаан хариуцсан хороо: Ч.Махбал
(Аймгийн морин спорт, уяачдын холбооны тэргүүн)

Сурын харваа хариуцсан хороо: Л.Мандал
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

0121092

Шагайн харваа хариуцсан хороо: Г.Нэмэхбаяр
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)

Зочид төлөөлөгчдөд өгөх бэлэг дурсгал хариуцсан хороо:
Б.Наранбаяр
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Соёл, урлаг, олон нийтийн арга хэмжээ хариуцсан хороо:
Ц.Азбаясгалан
(Аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Байгаль орчин, хот тохижилт, нийтийн хоол, үйлчилгээ хариуцсан хороо:
Г.Энхбаяр
(Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч)

Нийтийн хэв журам сахиулах хороо: Д.Сарангарав
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Хэвлэл мэдээлэл, баяр наадмын арга хэмжээг баримтжуулах хороо:
П.Отгонбаяр
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Аж ахуй, үйлчилгээ хариуцсан хороо: Ц.Түвшинжаргал
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)

Нарийн бичгийн дарга: Т.Норов
(Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Баяр наадмын үйл ажиллагааг зохион байгуулах салбар хороодын бүрэлдэхүүнийг баталж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, ажиллахыг зохион байгуулах хороо (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА Э.ЭНХБАТ